


“Арилжааны төлбөр тооцоо ҮЦК” ХХК



2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН





1. КОМПАНИЙН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

1.1 Компанийн эрхэм зорилго, зорилт, эрхэмлэх зарчмууд

Компанийн эрхэм зорилго

Хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн нэгэн гол хэсэг бүрэлдэхүүний хувьд, үнэт цаасны арилжааны дараах клиринг, төлбөр тооцоог шуурхай, найдвартай, тасралтгүй гүйцэтгэж, олон улсын жишигт нийцсэн үйлчилгээг үзүүлэх нь “Арилжааны төлбөр тооцоо ҮЦК” ХХК-ний эрхэм зорилго болно.

Компанийн эрхэм зорилт

- Үнэт цаасны арилжааны дараах төлбөр тооцоог олон улсын стандартад нийцүүлэн найдвартай гүйцэтгэж, харилцагч байгууллагуудад шуурхай, чирэгдэлгүйгээр үйлчлэх, хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн үйлчилгээг сайжруулан, байнгын шинэчлэл хийхийг эрмэлзэх
- Компанийн үйл ажиллагаанд учирч болох зах зээлийн, төлбөрийн чадварын, үйл ажиллагааны, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын, харилцагчийн зэрэг эрсдэлийг тооцоолох, үнэлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зэрэг эрсдэлийн удирдлагын цогц системийг бий болгон, үйл ажиллагаандаа нэвтрүүлэх
- Компанийн техникийн хангамж, цахим сүлжээний аюулгүй байдал, мэдээллийн нууцлал, түүний аюулгүй байдал, цахим сангуудын техникийн аюулгүй ажиллагааг хангаж, олон улсын төвшинд хүргэн, системийн хөгжүүлэлтийг нэн тэргүүнд тавьж ажиллана
- Компанийн үйл ажиллагааны үр өгөөжийг дээшлүүлэн, ашигтай ажиллагааны төвшинг нэмэгдүүлэн, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийг арвижуулахын төлөө ажиллах

Компанийн эрхэмлэх зарчмууд

Шударга ёс – Үнэт цаасны төлбөр тооцооны үйл ажиллагаанд шударга, шуурхай, мэргэжлийн, ил тод байх зарчмыг баримтална.

Найдвартай байдал – Үнэт цаасны төлбөр тооцооны үйл ажиллагааг оновчтой зохион байгуулж харилцагчдыг үнэн зөв мэдээллээр хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зарчмыг баримтална.

Хариуцлага хүлээх - Монгол улсын хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох журмуудыг үйл ажиллагаандаа чанд мөрдөж, хариуцлага хүлээх зарчмыг баримтална.

Өсөн дэвжих зарчим - Үндсэн үйл ажиллагаандаа байнга шинийг эрэлхийлэх, эдийн засаг санхүү, программ хангамж, удирдлага зохион байгуулалт, боловсон хүчний хувьд байнга өсөн дэвжих зарчмыг баримтална.

1.2 Компанийн товч танилцуулга

Монгол улсын Засгийн газрын 2015 оны 04-р сарын 17-ны өдрийн тогтоол Үнэт цаас, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх бодлогын хүрээнд Сангийн сайдын 2015 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн №280 дугаар тушаал, Сангийн сайдын 2016 оны 04-р сарын 13-ны өдрийн 138, 139 дүгээр тушаалын дагуу “Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн өөрчлөн зохион байгуулж, арилжааны төлбөр тооцоо гүйцэтгэх

чиг үүрэг бүхий зуун хувь төрийн өмчит “Арилжааны төлбөр тооцоо” ХХК-ийг үүсгэн байгуулсан.

Өмчийн хэлбэр: 100% төрийн өмчтэй, Хязгаарлагдмал хариуцлагатай компани (Төрийн өмчийн төлөөллийг Сангийн яамнаас баталсан Төлөөлөн удирдах зөвлөл хэрэгжүүлнэ.

Дүрмийн сангийн хэмжээ:

950,893,520.75 төгрөг

Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар:

9011596045

Регистрийн дугаар:

6051804

Хаяг:

“Арилжааны төлбөр тооцоо ҮЦК” ХХК,
Монгол улс, Улаанбаатар хот - 15160,
Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Сүхбаатарын
талбай – 3, Монголын хөрөнгийн биржийн
байр, 2-р давхар

Утас:

70110104, 70113672

Цахим хаяг:

www.mscc.mn

Үнэт цаасны арилжааны дүнд үүссэн төлбөрийг тодорхойлж, тооцоо хийх үйлчилгээг гэрээний үндсэн дээр эрхлэн гүйцэтгэх, арилжаанд оролцогчдын үнэт цаас болон мөнгөн төлбөрийн даалгаврыг холбогдох байгууллагууд руу илгээх зарчмаар баталгаажуулалтыг хийдэг.


Байгууллагын тооцооны үйл ажиллагааг схемээр харуулбал:



Зураг 1.1: Байгууллагын тооцооны үйл ажиллагаа




Зураг 1.2: Хөрөнгийн зах зээлийн клиринг, төлбөр тооцооны түүхэн замнал



1.3 Компанийн бүтэц зохион байгуулалт

Байгууллагын өнөөгийн бүтэц зохион байгуулалтыг схемээр харуулбал:

Зураг 1.3: Компанийн бүтэц зохион байгуулалт



2. ТӨЛБӨР ТООЦОО, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

2.1 Төлбөр тооцооны үйл ажиллагааны тойм

Тус компани нь Монголын хөрөнгийн бирж дээр арилжигдсан үнэт цаасны арилжааны төлбөр тооцоо, засгийн газрын үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөрийн гүйлгээг хийж гүйцэтгэж байна.

Өнөөдрийн байдлаар үнэт цаасны зах зээл дээр анхдагч ба хоёрдогч зах зээлийн гэсэн 2 төрлийн арилжааны төлбөр тооцооны горим үйлчилж байна.

2.1.1 Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны төлбөр тооцоо

МХБ дээр хийгдэж байгаа үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны төлбөр тооцоо T+0 өдрөө дараах зарчмаар хийгдэж байна.

Зураг 2.1: Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны төлбөр тооцоо



2017 онд “МХБ” ХК-ийн 44 удаагийн арилжаагаар Засгийн газраас гаргасан 81 төрлийн 630,204,874,833.00 төгрөгний үнэ бүхий 6 748 403 ширхэг үнэт цаас, 1 удаагийн арилжаагаар “Сүү” ХК-ийн гаргасан 6,000,000,000.00 төгрөгний үнэ бүхий 60,000 ширхэг бонд, “Ай түүлс” ХК-ийн гаргасан 1,338,798,000.00 төгрөгний үнэ бүхий 13,387,980 ширхэг хувьцааны, нийт 637,543,672,833 анхдагч зах зээлийн арилжааны төлбөр тооцоог хийж гүйцэтгэлээ.

Засгийн газрын үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаанд 35 ҮЦК оролцож гадаадын 244 иргэн, 9 ААН, дотоодын 1 582 иргэн, 284 аж ахуйн нэгж оролцож нийт 2,289 хэлцэл хийж, 1,035,711,945.36 төгрөгийн шимтгэл тооцогдсон байна.

“Сүү” ХК-ийн гаргасан бондын анхдагч зах зээлийн арилжаанд 11 ҮЦК оролцож гадаадын 3 иргэн, дотоодын 100 иргэн, 7 аж ахуйн нэгж оролцож нийт 17,862,675.00 төгрөгийн шимтгэл тооцогдсон байна.

“Ай түүлс” ХК-ийн гаргасан хувьцааны анхдагч зах зээлийн арилжаанд 29 ҮЦК оролцож гадаадын 14 иргэн, дотоодын 936 иргэн, 5 аж ахуйн нэгж оролцож, нийт 31,318,400.28 төгрөгийн шимтгэл тооцогдсон байна.




Хүснэгт 2.1: Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны мэдээ

| Үнэт цаас | Дотоод иргэн | Дотоод ААН | Гадаад иргэн | Гадаад ААН | Нийт |
|----------------|------------------------|------------------------|-----------------------|----------------------|------------------------|
| ЗГҮЦ | 124,719,880,889 | 478,690,741,190 | 18,949,087,240 | 7,845,165,514 | 630,204,874,833 |
| Компанийн бонд | 2,854,500,000 | 3,125,900,000 | 19,600,000 | - | 6,000,000,000 |
| Хувьцаа | 1,178,971,500 | 19,891,500 | 139,935,000 | - | 1,338,798,000 |
| Нийт | 128,753,352,389 | 481,836,532,690 | 19,108,622,240 | 7,845,165,514 | 637,543,672,833 |

Зураг 2.2: Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа (2017 он)

(төгрөг)



Зураг 2.3: Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны шимтгэлийн судалгаа



Засгийн газрын үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа 2017 оны 10-р сарын 24-нөөс хойш явагдаагүй.

2.1.2 Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааны төлбөр тооцоо

МХБ дээр хийгдэж байгаа үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааны төлбөр тооцоо нь Төлбөр гүйцэтгэгч банканд дээр Т+1 хугацаанд дараах зарчмаар хийгдэж байна.

Зураг 2.4: Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааны төлбөр тооцоо



2017 онд МХБ-ээр нийт 249 удаагийн арилжаа явагдсан бөгөөд үүнээс 249 удаагийн арилжаанд 75,110,227,352.69 төгрөгний хувьцааны, 171 удаагийн арилжаанд нь 143,285,402,386.83 төгрөгний ЗГҮЦ-ны, 43 удаагийн арилжаанд 4,295,590,910.97 төгрөгний компанийн бондын, нийт 222,691,220,650.50 төгрөгний хоёрдогч зах зээлийн арилжаа явагдсан байна.

Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааны төлбөр тооцоо нь T+1 хугацаанд Төлбөр гүйцэтгэх банкууд дээр хийгдэж байгаа бөгөөд АТТ нь цэвэршүүлсэн дүнгээр нийт 54,646,690,316.78 төгрөгний банк хоорондын гүйлгээг хийж гүйцэтгэлээ.


Хүснэгт 2.2: Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааны мэдээ

(төгрөг)

| Үнэт цаас | Дотоод иргэн | Дотоод ААН | Гадаад иргэн | Гадаад ААН | Нийт |
|----------------|--------------------------|---------------------------|-------------------------|-------------------------|---------------------------|
| ЗГҮЦ | 12,783,485,854.12 | 126,514,415,572.47 | 3,124,123,996.36 | 863,376,963.89 | 143,285,402,386.83 |
| Компанийн бонд | 2,260,808,462.32 | 1,754,471,523.77 | 280,310,924.88 | - | 4,295,590,910.97 |
| Хувьцаа | 23,909,725,083.20 | 47,507,820,533.34 | 1,805,546,247.36 | 1,887,135,488.79 | 75,110,227,352.69 |
| Нийт | 38,954,019,399.64 | 175,776,707,629.58 | 5,209,981,168.60 | 2,750,512,452.68 | 222,691,220,650.50 |

Зураг 2.5: Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа (2017)

(төгрөг)





Хүснэгт 2.3: Төлбөр гүйцэтгэх банкнуудаар хийж гүйцэтгэсэн төлбөрийн гүйлгээ (цэвэршүүлсэн дүнгээр)

(сая төгрөг)

| д/д | Төлбөр гүйцэтгэгч банк | 2016 | 2017 |
|-----|------------------------|------------------|------------------|
| 1 | Голомт банк | 4,890.00 | 11,385.67 |
| 2 | ХХБ | 4,486.30 | 11,378.63 |
| 3 | Хас банк | 7,431.80 | 18,533.72 |
| 4 | ХААН банк | 739.30 | 13,348.67 |
| | Нийт | 17,547.40 | 54,646.69 |

ЗГҮЦ-ны үндсэн болон хүүгийн төлбөрийн гүйлгээ

АТТ ХХК нь үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаанд оролцогчдын мөнгөн хөрөнгийн гүйлгээг хийхээс гадна Засгийн газрын үнэт цаасны үндсэн ба хүүгийн төлбөрийг харилцагчдад тараах үйл ажиллагааг 2016 оны 09 дүгээр сарын 19-ны өдрөөс “ҮЦТХТ” ХХК-аас шилжүүлэн авч гүйцэтгэж байна.

Хүснэгт 2.4: Мөнгөн хөрөнгийн гүйлгээ

(сая төгрөг)

| Он | Эхний үлдэгдэл | Орлого | | Зарлага | Эцсийн үлдэгдэл |
|------|----------------|--------------|---|--------------|-----------------|
| | | Нийт | Үүнээс: ЗГҮЦ-ны үндсэн болон хүүгийн төлбөр | | |
| 2016 | - | 859,278.93 | 523,101.33 | 859,188.32 | 90.61 |
| 2017 | 90.61 | 5,411,501.89 | 4,026,188.25 | 5,409,420.84 | 2,171.67 |

Үнэт цаасны арилжааны шимтгэл

АТТ ХХК нь 2016 оны 04 дүгээр сарын 18-ны өдрөөс өөрийн болон үнэт цаасны зах зээлд оролцогч бусад байгууллагын шимтгэл хураамжийн тооцоог хийж, холбогдох байгууллагуудад хуваарилан төлбөр тооцоог гүйцэтгэсэн.

Үнэт цаасны зах зээл дэх үйлчилгээний хөлсний хэмжээг судлахад дараах дүгнэлтэнд хүрч байна. Үүнд:

1. Шимтгэлийн хувь хэмжээ нь оролцогч байгууллагуудын хувьд харьцангуй адилгүй бөгөөд зах зээлд гүйцэтгэх үүрэг, оруулдаг хувь нэмрийг үндэслэн бодитойгоор тогтоох шаардлагатай байна. Үүнтэй холбоотойгоор 2016 онд ЗГҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжааны шимтгэлийн хувьд өөрчлөлт оруулах шийдвэрийг ТУЗ-өөр гаргуулсан боловч 2017 онд Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хорооноос уг шимтгэлийг хүчингүй болгохыг шаардсан.
2. Цаашдаа зах зээл дээр шинэ бүтээгдэхүүн гарах тохиолдолд шимтгэлийн хувь хэмжээг олон улсын ижил төстэй байгууллагуудын туршлагыг судалж, клиринг, төлбөр тооцооны байгууллагыг дэмжин хөгжүүлэх үүднээс зах зээлийн үнэлгээ, бодит хувь нэмрийг нь үнэлж тогтоох шаардлагатай байна
3. Зохицуулах эрх бүхий байгууллагын шимтгэлийн хувь хэмжээг арилжааны үнийн дүнтэй уялдуулан тогтоох уу, тогтмол хувь хэмжээтэй байх уу гэдгийг эргэж харах шаардлагатай гэж үзэж байна.

АТТ ХХК нь 2017 онд МХБ-ээр хийгдсэн арилжааны төлбөр тооцоог гүйцэтгэж нийт 1,934.0 сая төгрөгийн шимтгэлийн тооцоо хийсэн байна.

Жич: Нийт шимтгэлийн дүнд ҮЦК-уудын хувьд зөвхөн үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаанаас тооцогдсон шимтгэлийн дүн орсон.





Хүснэгт 2.5: Арилжааны шимтгэлийн үзүүлэлт, 2016 - 2017

(мян. төгрөг)

| Байгууллагын нэр | 2016 | | 2017 | |
|-----------------------------|-------------------|----------------|---------------------|----------------|
| Арилжааны төлбөр тооцоо ХХК | 192,031.10 | 26.44% | 351,328.17 | 18.17% |
| Монголын хөрөнгийн бирж ХК | 478,177.10 | 65.83% | 1,123,746.19 | 58.10% |
| ҮЦК-иуд /анхдагч зах зээл/ | 56,168.80 | 7.73% | 216,657.18 | 11.20% |
| Санхүүгийн зохицуулах хороо | 0.00 | 0.00% | 242,288.39 | 12.53% |
| Нийт | 726,377.00 | 100.00% | 1,934,019.93 | 100.00% |

Зураг 2.6: Арилжааны шимтгэлийн үзүүлэлт, 2016 – 2017



Хүснэгт 2.6: МХБ-ийн арилжаанд тооцогдсон шимтгэлийн тайлан (зах зээл тус бүрээр)

(мян төгрөг)

| | 2017 | | ЗГҮЦ /анхдагч/ | | ЗГҮЦ /хоёрдогч/ | | КБ /анхдагч/ | | КБ /хоёрдогч/ | | Хувьцаа /хоёрдогч/ | |
|-------------|---------------------|---------------|------------------|---------------|------------------|---------------|-----------------|---------------|------------------|---------------|--------------------|---------------|
| | Дүн | % | Дүн | % | Дүн | % | Дүн | % | Дүн | % | Дүн | % |
| АТТ ХХК | 31,195.14 | 2.96 | 7,076.74 | 34.73 | 810.00 | 4.53 | 571.41 | 41.66 | 5,783.61 | 17.67 | 305,891.28 | 37.92 |
| МХБ ХК | 723,522.07 | 68.58 | 11,254.85 | 55.24 | 9,450.00 | 52.90 | 666.64 | 48.60 | 9,639.35 | 29.46 | 369,213.28 | 45.77 |
| ҮЦК-иуд | 196,671.51 | 18.64 | - | 0.00 | 5,816.41 | 32.56 | - | 0.00 | 14,169.26 | 43.30 | - | 0.00 |
| СЗХ | 103,571.42 | 9.82 | 2,042.41 | 10.02 | 1,786.27 | 10.00 | 133.69 | 9.75 | 3,131.84 | 9.57 | 131,622.76 | 16.32 |
| Нийт | 1,054,960.14 | 100.00 | 20,374.00 | 100.00 | 17,862.68 | 100.00 | 1,371.74 | 100.00 | 32,724.05 | 100.00 | 806,727.32 | 100.00 |

Үнэт цаасны арилжаанд оролцогчдын талаарх судалгаа



Үнэт цаасны арилжаанд дотоодын иргэдийн оролцоо сүүлийн үед нилээд нэмэгдэж байна. Ялангуяа хадгаламжийн хүүнээс татвар авах болсонтой холбоотойгоор иргэд ЗГҮЦ-ны арилжаанд орох нь эрс нэмэгдэж байна.

Хүснэгт 2.7: Гадаад дотоодын хөрөнгө оруулагчдын арилжааны үнийн дүнд эзлэх хувь

| Үзүүлэлт | | 2016 | | | 2017 | | |
|-------------|-------|------------------------|----------------------|----------------|------------------------|------------------------|----------------|
| | | Арилжаанд оролцсон тоо | Дүн | Хувь | Арилжаанд оролцсон тоо | Дүн | Хувь |
| Гадаадын | ААН | 1,992 | 1,797,418.1 | 0.52% | 2,972 | 10,595,678.0 | 1.23% |
| | Иргэн | 844 | 6,521,268.9 | 1.87% | 1,902 | 24,318,603.4 | 2.83% |
| Дотоодын | ААН | 2,243 | 312,462,540.8 | 89.61% | 3,123 | 657,613,240.0 | 76.44% |
| | Иргэн | 9,779 | 27,903,591.5 | 8.00% | 30,072 | 167,707,371.8 | 19.50% |
| Нийт | | 14,858 | 348,684,819.3 | 100.00% | 38,069 | 1,208,919,712.8 | 100.00% |



Зураг 2.7: Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын арилжааны дүнд эзлэх хувь





“Арилжааны төлбөр тооцоо ҮЦК” ХХК

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот
Чингэлтэй дүүрэг, 1-р хороо
Сүхбаатарын талбай- 3
“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн байр

Утас: 7011-0104, 7011-3672

Имэйл: info@mscc.mn

Вэб хуудас: www.mscc.mn

